



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8 нэрийн, нийт 66,785,588.00 (жаран зургаан сая долоон зуун наян таван мянга таван зуун наян найман) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Чиргүүлийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 05 дугаар сарын .....-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН  
 ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Зургийн камер sonu /мемори 16 GB, хөл FPU-SZO2/	2016-01-27	ш	1	699,636.00	699,636.00
2	Зургийн аппарат/иж бүрдэл мемору SD 16GB/	2016-02-15	ш	1	390,727.00	390,727.00
3	Дымсос Y6--41-11NO9C-2/буулгасан к4/	2006-12-19	ш	1	5,916,005.00	5,916,005.00
4	К-1 Халаах гадаргуу Өрлөгө дулаалга	2006-12-19	ш	1	53,458,311.00	53,458,311.00
5	Даралтын трансмитер датчик/хэмжүүр /	2011-12-31	ш	2	465,000.00	930,000.00
6	Гинжин цень/Үнсний конвейер/	2013-07-24	ш	100	15,000.00	1,500,000.00
7	Ф-200 тоолуур /электрон,усан сан/	2013-03-31	ш	1	1,090,909.00	1,090,909.00
8	Компьютер	2013-11-29	ш	1	2,800,000.00	2,800,000.00
						66,785,588.00
<b>НИЙТ ДҮН</b>						<b>(жаран зургаан сая долоон зуун наян таван мянга таван зуун наян найман төгрөг)</b>